



ОРХОН АЙМГИЙН
ЗАСАГ ДАРГЫН ДЭРГЭДЭХ ЭРҮҮЛ МЭНДИЙН ГАЗРЫН
ДАРГЫН ТУШААЛ

2020 оны 12 сарын 28 -ны өдөр

Дугаар А/152

Эрдэнэт

"Коронавируст халдвар /COVID-19/-ын цар тахлаас урьдчилан сэргийлэх, тусламж үйлчилгээний бэлэн байдлыг хангах, хариуцлагатай жижүүр томилох тухай"

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 33 дугаар зүйлийн 33.5, Нийтээр тэмдэглэх баярын болон тэмдэглэлт өдрүүдийн тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.4 дэх заалт, Коронавируст халдвар /COVID-19/-ын цар тахлаас урьдчилан сэргийлэх, тэмцэх, нийгэм, эдийн засагт үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах тухай хуулийн 7 дугаар зүйл, Хөдөлмөрийн тухай хуулийн 50 дугаар зүйлийн 50.2, 52.1, 76.1.1 дэх заалт, Эрүүл мэндийн сайдын 2020 оны 01 дүгээр сарын 24-ний өдрийн "Журам батлах тухай" А/36 дугаар тушаал, Аймгийн Засаг даргын 2020 оны "Хариуцлагатай эргүүл ажиллуулах тухай" А/806 дугаар захирамжийг тус тус үндэслэн ТУШААХ НЬ:

1. Шинэ жилийн баярын өдрүүдэд Коронавируст халдвар /COVID-19/-ын цар тахлаас урьдчилан сэргийлэх, эмнэлгийн тусламж үйлчилгээний хэвийн үйл ажиллагааг хангах, шуурхай хариу арга хэмжээ авах зорилгоор 2020 оны 12 дугаар сарын 30-ний өдрөөс эхлэн 2021 оны 01 дүгээр сарын 04-ний өдөр хүртэл ажиллах Эрүүл мэндийн газрын хариуцлагатай жижүүрийн нэрсийг нэгдүгээр, Гамшиг, нийгмийн эрүүл мэндийн ноцтой байдлын үед ажиллах багийн бүрэлдэхүүнийг хоёрдугаар, Хариуцлагатай жижүүрийн ажиллах журмыг гуравдугаар хавсралт, Эрүүл мэндийн байгууллагуудын ажиллах цагийн хуваарийг дөрөвдүгээр хавсралтаар тус тус баталсугай.

2. Эрүүл мэндийн байгууллагууд шинэ жилийн баярын өдрүүдэд хариуцлагатай жижүүр томилж, эмнэлгийн тусламж үйлчилгээний бэлэн байдлыг ханган ажиллахыг салбар байгууллагуудын /захирал, дарга/ нарт үүрэг болгосугай.

3. Бүсийн оношилгоо эмчилгээний төв, Жаргалант сумын эрүүл мэндийн төв, Өрхийн эрүүл мэндийн төвүүдийн хариуцлагатай жижүүрүүд тусламж үйлчилгээний мэдээллийг Эрүүл мэндийн газрын хариуцлагатай жижүүрт ирүүлэх, Эрүүл мэндийн газрын хариуцлагатай жижүүр мэдээллийг нэгтгэн Эрүүл мэндийн газрын даргад болон аймгийн Онцгой комиссын шуурхай штабт удирдлагуудад танилцуулан холбогдох арга хэмжээ авч ажиллахыг Эрүүл мэндийн газрын хариуцлагатай жижүүрүүдэд үүрэг болгосугай.

4. Хариуцлагатай жижүүрээр ажилласан албан хаагчдад нэмэгдэл хөлсийг холбогдох хууль тогтоомжид заасны дагуу бодож олгохыг Салбарын санхүү бүртгэл мэдээлэл, нягтлан бодохын ажилтан /Н.Чулуун-Эрдэнэ/ зөвшөөрсүгэй.

5. Тушаалын хэрэгжилтийг хангаж, хяналт тавьж ажиллахыг Нийгмийн эрүүл мэндийн төв /А.Баярхүү/-д үүрэг болгосугай.

ЭРҮҮЛ МЭНДИЙН ГАЗРЫН ДАРГЫН
ҮҮРГИЙГ ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ



Д.СҮХЭЭ

My doc. EMG-iin dargiin tushaal


Эрүүл мэндийн газрын даргын 2020 оны
11 дугаар сарын 18-ний өдрийн
1152 дугаар тушаалын нэгдүгээр хавсралт



Шинэ жилийн баярын өдрүүдэд ажиллах Эрүүл мэндийн
газрын хариуцлагатай жижүүрийн нэрс, хуваарь

Д/Д	Овог, нэр	Албан тушаал	Утасны дугаар	Жижүүр хийх өдөр, цаг	Ажиллах цаг
1	П.Хишгээ	Эх барих эмэгтэйчүүдийн тусламж үйлчилгээ хариуцсан мэргэжилтэн	99359900	2020.12.30-ны өдөр	08.00-20.00 цаг
2	Н.Мөнгөн-цацралт	Халдварт бус өвчин тандалт, сэргийлэлт хариуцсан ажилтан	95341446	2020.12.31-ны өдөр	08.00-20.00 цаг
3	Ө.Наранзаяа	Эрүүл мэндийн боловсрол, олон нийт, сургалт сурталчилгаа хариуцсан ажилтан	95545509	2021.01.01-ны өдөр	08.00-20.00 цаг
4	Т.Нарантуяа	Уламжлалт анагаах ухаан сэргээн засах тусламж үйлчилгээ, хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн асуудал хариуцсан ажилтан	99126635	2021.01.02-ны өдөр	08.00-20.00 цаг
5	О.Анхбаяр	Эмийн бодлогын хэрэгжилт чанар аюулгүй байдал, эм, эмнэлгийн хэрэгслийн хангамж хариуцсан мэргэжилтэн	94351290	2021.01.03-ны өдөр	08.00-20.00 цаг

Эрүүл мэндийн газрын даргын 2020 оны
12 дугаар сарын 21-ний өдрийн 21/12 дугаар
тушаалын хоёрдугаар хавсралт



Гамшиг, нийгмийн эрүүл мэндийн ноцтой байдлын үед ажиллах баг

№	Овог нэр	Албан тушаалын нэр	Утасны дугаар	Баг
1	Б.Уртнасан	Яаралтай, гамшгийн үеийн тусламж үйлчилгээ хариуцсан мэргэжилтэн	99950350	Ахлагч
2	А.Баярхүү	Сувилахуй, хөнгөвчлөх тусламж үйлчилгээний асуудал хариуцсан мэргэжилтэн	99368309	Гишүүн
3	Б.Билгүүнээ	Амьсгалын зам, сүрьеэгийн тандалт сэргийлэлт хариуцсан ажилтан	99365132	Гишүүн
4	О.Анхбаяр	Эмийн бодлогын хэрэгжилт, чанар аюулгүй байдал, эмийн зохистой хэрэглээ, эм эмнэлгийн хэрэгслийн хангамж хариуцсан мэргэжилтэн	94351290	Гишүүн
5	Б.Нямдорж	жолооч	99290320	Гишүүн
6	Л.Даваажав	нярав	99364946	Гишүүн
7	Т.Гонгорням	НЭМТөвийн жижүүр	95552964	Гишүүн
8	Б.Батжаргал	НЭМТөвийн жижүүр	99559464	Гишүүн

ХАРИУЦЛАГАТАЙ ЖИЖҮҮРИЙН АЖИЛЛАХ ЖУРАМ

1. Эрүүл мэндийн газрын хариуцлагатай жижүүрүүд 2020 оны 12 дугаар сарын 30-ны өдрөөс эхлэн 2021 оны 01 дүгээр сарын 04-ний өдөр хүртэл /COVID-19/-ын цар тахлаас урьдчилан сэргийлэхэд Бүсийн оношлогоо эмчилгээний төв, Сум, Өрхийн эрүүл мэндийн төвийн тусламж үйлчилгээний бэлэн байдалд хяналт тавьж ажиллана.

2. Хариуцлагатай жижүүрүүд Эрүүл мэндийн газар, Бүсийн оношилгоо эмчилгээний төв, Сум, Өрхийн эрүүл мэндийн төвийн тусламж үйлчилгээний бэлэн байдалд хяналт тавьж тэмдэглэл хөтлөн өдөр бүр 08.00, 18.00 цагт мэдээллийг нэгтгэж Эрүүл мэндийн газрын даргын утсанд мэдээлнэ.

3. Хариуцлагатай жижүүр нь эрүүл мэндийн байгууллагуудаас ирсэн мэдээнд хяналт тавин, мэдээний үнэн зөвийг хариуцан ажиллана.

4. Хариуцлагатай жижүүрийн дэвтэрт үйл явцын тайлан бичиж дараагийн жижүүрт хүлээлгэн өгнө.

5. Эрүүл мэндийн байгууллагууд /БОЭТ, Жаргалант СЭМТ, ӨЭМТ-үүд/ мэдээг 12 цагаар өгөх ба COVID-19 халдварт өвчний шинж тэмдэг бүхий дуудлага, олон хүнийг хамарсан хордлого, осол гэмтэл, эх, хүүхдийн ноцтой хүндрэл гарсан тохиолдолд хугацаа харгалзахгүй тухайн өдөр хяналт тавих Эрүүл мэндийн газрын хариуцлагатай жижүүрт шуурхай мэдээлнэ.

6. Нийтийг хамарсан ноцтой тохиолдлын шалтгаан болон нас баралт бүртгэгдсэн үед тухайн хүний нэр, нас, хүйс, хаяг, оношийн талаар тодорхой мэдээллийг эрүүл мэндийн байгууллагаас авч, мэдээллийн хүснэгтэд нэмэлт тайлбар бичиж тэмдэглэн бүртгэн авах.

7. Шаардлагатай тохиолдолд аймгийн Онцгой комиссийн Шуурхай штаб, Цагдаагийн газар, Мэргэжлийн хяналтын газар бусад байгууллагуудтай мэдээ мэдээллийг солилцож хамтран ажилласан тухай тэмдэглэл хөтлөх.

8. Жижүүр хийсэн мэргэжилтнүүд эрүүл мэндийн байгууллагуудаас авсан мэдээлэлд гарын үсэг зурж баталгаажуулан, Эрүүл мэндийн газрын шуурхай штабын жижүүрт цаасаар 2021 оны 01 дүгээр сарын 04-ний өдрийн өглөө хүлээлгэн өгнө.

9. Хариуцлагатай жижүүр нь цагаас хоцрох буюу тухайн өдөртөө жижүүрийн үүргийг тасалдуулах, мэдээ дутуу авах болон дутуу өгөх, мэдээг албажуулан нэгтгэл хийхгүй буух, хариуцлагатай жижүүрийн үүрэг, үйл ажиллагаанд тусгасан асуудлыг шалтгаангүй зөрчихийг хориглоно.

Эрүүл мэндийн газрын даргын 2020 оны
12 дугаар сарын 21-ний өдрийн 12/2020 дугаар
тушаалын дөрөвдүгээр хавсралт

Эрүүл мэндийн байгууллагуудын ажиллах цагийн хуваарь

д/д	Эрүүл мэндийн байгууллагын нэр	XII/31	I/01	I/02	I/03
1	Эрүүл мэндийн газар	08.00-20.00	08.00-20.00	08.00-20.00	08.00-20.00
2	Бүсийн оношилгоо эмчилгээний төв	24 цаг	24 цаг	24 цаг	24 цаг
3	Жаргалант сумын эрүүл мэндийн төв	24 цаг	24 цаг	24 цаг	24 цаг
4	Анхны-оч Өрхийн эрүүл мэндийн төв			10.00-16.00	10.00-16.00
5	Мэндцэцэн Өрхийн эрүүл мэндийн төв			10.00-16.00	10.00-16.00
6	Нийцэл Өрхийн эрүүл мэндийн төв			10.00-16.00	10.00-16.00
7	Учралтбаяр Өрхийн эрүүл мэндийн төв			10.00-16.00	10.00-16.00
8	Мөнхсүндрэл Өрхийн эрүүл мэндийн төв			10.00-16.00	10.00-16.00
9	Энхжихмандариваа Өрхийн эрүүл мэндийн төв			10.00-16.00	10.00-16.00
10	Мөнхийн гэгээ Өрхийн эрүүл мэндийн төв			10.00-16.00	10.00-16.00
11	Үйлсбадрах Өрхийн эрүүл мэндийн төв			10.00-16.00	10.00-16.00